

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Я.Цэлмэн.

ХСИС-ийн Цагдаагийн Сургуулийн МАОТТ-ийн
ахлах багш, докторант цагдаагийн ахмад

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2.27 дахь заалтад "Хүн бүр эдийн болон сэтгэл зүйн хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй" гэжээ. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт эдийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар хангалттай бус байгаа, сэтгэл зүйн хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх асуудал бүр ч орхигдсон. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт: "Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд заасан эрх эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...эрхтэй" гэсэн нь үндсэндээ салбар хуулиудаар нарийн зохицуулагдахгүй байсаар өдий хүрлээ.

АНУ-ын тэргүүн хатагтай асан Элеанор Рузвельт "Хүний эрх бол маш жижиг зүйлээс эхэлдэг. Энэ нь тухайн хүний амьдарч буй болон оршин суугаа газар, ажил, сургууль, байр, орон сууц гээд тэр бүхэнд бий. Яг энд л хүн бүр тэгш эрхтэй, ялгаварлан гадуурхагдахгүй байхыг хүсдэг.Тиймээс хаа нэгтэйгээс хайгаад нэмэргүй" гэж хэлсэн байдаг.

Бид нэгэнтээ хүмүүнлэг, иргэний ардчилсан гэх хаягтай нийгмийг бүтээхээр зориод 20 гаруй жилийг ардаа нэгэнт орхисон. Хүний амьтнаас ялгарах зүйл нь оюун ухаан, сэтгэл санаа байдаг тухай хүн төрөлхтөн ойлгодог. Гэтэл төрийн эрх баригч, хууль тогтоогчид маань өнгөрсөн жилүүдэд хүнийхээ эрхэм зүйл болсон сэтгэл зүйн асуудлыг зоригтой хөндөж асуудлыг нь шийдэж чадахгүй байсаар өнөөдрийг хүрээд байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.”¹ гэж заасан. Энэ заалтаас гэмт хэрэг гэдэг нь өөрөө нийгэмд аюултай гэсэн шинж гарч ирж байна. Нийгэмд аюултай байх шинж чанар нь өөрөө хохирол учирсан байхыг шаардана. Хэл зүйн талаас нь авч үзвэл “Хохирол”² гэдэг нь алдагдал, алдах гэсэн утгыг илэрхийлж байна. Тэгвэл гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Монгол Улсын Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд заасан “Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ”³ гэсэн тодорхойлолтын хүрээнд ойлгож болхоор байна.

Судлаачид гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг олон янз байдаг гэж үздэг боловч үндсэнд нь: 1.Эдийн хохирол,

2.Эдийн бус хохирол гэж хувааж болно.

Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт "Эдийн бус хохирол гэдэг нь материаллаг бус бүх хохирлыг хэлнэ хэмээн тайлбарлаж, бие эрхтэн болон сэтгэцийн хохирол, амьдралын баярбаясгалан байхгүй болох" зэргийг хамааруулсан байна. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол материаллаг хохирлыг арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэж заасан.

Эрх зүй өндөр хөгжсөн зарим улс орнуудад гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирол гаргуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд хөрөнгө бие эрхтэнд учирсан хохирлоос гадна сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг тогтолцоо байдаг байна.Гадаад орнуудын хууль зүйн практикт энэ талаар нэлээд тодорхой авч үздэг. Тухайлбал:

¹Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2002 №5

²Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966.699 дэх тал

³Монгол Улсын Эрүүгийн Байцаан Шийтгэх хууль. Төрийнмэдээлэл. УБ., 2002. №6

Оросын Холбооны Улсын иргэний эрх зүйн тайлбарт “Гэм хор гэдэг нь аливаа эд хөрөнгийн эрх эсхүл материаллаг бус баялагт халдсан болон зөрчигдсөн байдлыг ойлгоно. Эд хөрөнгийн бус хохиролыг бие махбодийн хохирол, - ёс суртахууны хохирол гэж хуваадаг” гэсэн байдаг.

ХБНГУ-н Иргэний хуулийн 253 дугаар зүйлийн 253.1-д "зөвхөн хуульд заасан тохиолдолд аливаа хохирлын нөхөн төлбөрт мөнгөн торгууль ногдуулж болно", мөн хуулийн 847 дугаар зүйлд "сэтгэл санааны гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэхээр заасан бөгөөд тийнхүү нөхөн төлүүлэх үндэслэл нь хохирогчийн эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарласан, бие эрхтэн, эрүүл мэндийг гэмтээж хохирол учруулсан" байхыг шаардсан байна.

Япон Улсын эрх зүйн тайлбарт гэм хор буюу сэтгэл санааны хохирол гэж зөрчил гаргасан, гэм буруутай этгээдийг шийтгэх зорилгоор гомдол гаргагчид шууд учирсан хохиролоос илүү хэмжээний мөнгөн төлбөр олгох шийдвэрийг шүүхээс гаргахыг хэлнэ. Үүний үр дагавар болох гэм хор, хохирол нь эд хөрөнгийн бус "өвчин зовлон" учруулах нэмэлт нөхцөлтэйгээр л нэхэмжлэгчийн алдагдал, зардлыг нотолсны үндсэн дээр тооцогдоно" гэжээ.

БНХАУ-д эдийн бус гэм хорыг тооцох аргачлалгүй харин тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүхээс тогтоодог байна.

Европын холбооны улсуудад шүүхийн практик болон хуульчдын дунд эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэхтэй холбоотой бүрдүүлвэр асуудлын нэг болох нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэрхэн тодорхойлж ойлгосноос шалтгаалан түүнийг сэргээх, гэм хорыг нь арилгах, нөхөн төлүүлэх аргыг тогтоох боломж бүрддэг.

Австрали, Их Британи зэрэг оронд хэн ч нэр төрөө сэргээх нэхэмжлэл гаргаж болно. Шүүхээс үндсэн 4 элементийг хангасан тохиолдолд тухайн гаргаж буй нэхэмжлэлийг хүлээн авхаар зохицуулсан. Үүнд:

- Бодит байдалд нийцээгүй мэдээлэл түгээсэн бол,
- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол,
- Тодорхой байгууллага, хувь хүний нэр зааж, танигдахаар бичсэн, дүрсэлсэн бол, /гэхдээ заавал шууд тусгахгүй байж болно/
- Бодит баримт, болсон үйл явдал дээр тулгуурлаагүй бол гэсэн үндэслэлтэй байх ёстой.⁴

Австралид эдийн бус гэм хорын ойлголт өргөн хүрээтэй бөгөөд түүнийг үнэлэх, арилгах журмыг буюу эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг хуульчилсан байна. Тухайлбал: эд хөрөнгийн хохирлыг шүүхээс 0-60 түвшинд хуваан авч үзэж хохирлыг үнэлэхээр заажээ.

Манай улсын хууль тогтоомжид сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар шууд заасан заалт байхгүй. Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Иргэний эрхийг эдийн бус гэм хорыг арилгуулах аргаар хамгаална”, 497 дугаар зүйлд “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэл/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй “ гэж заасан.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасны дагуу өөрөөр хэлбэл эд хөрөнгийн болон эдийн бус эрх нь зөрчигдсөн үед гэм хор нөхөн төлүүлэхээр заасан боловч гэм хорын төрлийг нарийн зааглаж өгөөгүй байна. Эндээс үзвэл иргэний хуульд заасан гэм хорын хоёр төрлийн аль алиныг нь ч төлүүлж болохоор ойлгогдож байна. Гэтэл 511 дүгээр зүйлд зааснаас харахад зөвхөн эдийн бус гэм хор учирсан тохиолдолд сэтгэл санаанд учирсан үр дагаврыг харгалзан үзэх талаар заасан байдаг. Үүнээс гадна иргэний хуулийн 511.3-т заасны дагуу уг хуулийн 21.4, 21.5, 21.6-д заасан зөрчлүүд буюу хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг тухайн иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл, иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүй нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан зэрэг нь мөн эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэх үндэслэл болох байна.

⁴<http://www.trends.mn/n/2979>

Эд хөрөнгийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох асуудлын талаар Улсын Дээд Шүүхийн Иргэний танхимаас шинэ Иргэний хууль батлагдахаас өмнө буюу 2000 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зөвлөмж гаргасан байдаг. Гэхдээ шинэ Иргэний хуультай төсөөтэй хэрэглэгдэх бололцоотой юм. Тус зөвлөмжид дараах байдлаар эдийн бус гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх аргачлалыг гаргасан байна. Шүүхэд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан аргах эрэгсэл, тарсан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзана гэдгийг доорхи утгаар ойлгоно. /хуучин Иргэний хуулийн 392 дугаар зүйл, шинэ Иргэний хуулийн 511 дүгээрзүйл/

Сэтгэл санааны хохирлыг үнэлэх аргачлал:

- Мэдээ тараасан арга
- Тараасан хэрэгсэл
- Тарсан хүрээ
- Сэтгэлийн шаналал, үр дагавар
- Хувийн үнэлгээ

Эдийн бус хохирол гаргуулахын тулд гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирол хүлээсэн этгээд тухайн хохирлоо нөхөн төлүүлэхээр Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах төрийн байгууллага, албан тушаалтанд нэхэмжлэл гаргаж болно. Энэхүү нэхэмжлэлд гэмт хэргийн улмаас сэтгэл санаанд учирсан таагүй үр дагавар болон бие эрхтний өвчин шаналал, зовиур гэх мэт хохирлыг нөхөн төлүүлэх эрхээ хангуулахаар гаргасан нэхэмжлэл хамаарах юм.

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл зүйн хохирлыг арилгахтай холбоотой Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зохицуулалтыг хэрхэн нэг мөр ойлгож, шүүхийн практикт зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолд: “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус холхирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй”⁵ гэж заасан. Дээрх тайлбарт Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хохирогчид олгосон эрхийг хязгаарлаж “эдийн бус гэм хор буюу хохирлыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөх”-өөр зохицуулсан нь учир дутагдалтай юм.

Нөгөөтэйгүүр бас нэг анхаарах томоохон асуудал бол эдийн бус буюу сэтгэл санааны гэм хор учирсан гэх хүн буюу нэхэмжлэл гаргагч маань өөрийн хохирсон гэх үнэлгээгээ мөнгөн хэлбэрээр тооцон нэхэмжлэх, түүнийг нь шүүх, хууль хяналтынхан хэрхэн үнэлэн тооцох аргачлал өнөөдөр манай практикт хангалтгүй байгаа болно. Үүнээс шалтгаалан нэхэмжлэл гаргагчид өөрсдийн тооцоолсноор буюу төсөөллөөр нэхэмжлэлийн мөнгөн хэлбэрээ хүссэнээрээ илэрхийлдэг асуудал байна.

Энэ бүхнээс үндэслэн дараах дүгнэлтэнд хүрч байна. Сэтгэл санааны хохирлыг үнэлэхэд төвөгтэй, хуулинд нарийн зохицуулалт байхгүй, мөн нэхэмжлэгч нь сэтгэл санааны хохирлоо нотлож чаддаггүй, баримт сэлт гаргаж өгдөггүй зэрэг нь хууль, шүүхийн практикт төвөг учруулдаг. Иймээс хохирлын үнэлгээ тооцох аргачлалыг боловсруулж, үнэлгээчдийг нэгдсэн сургалтанд хамруулж мэргэжлийн зөвшөөрөл олгох, үнэлгээ хийхэд шүүхийн шинжилгээ хийхтэй нэгэн адил хууль эрх зүйн үр дагавартай болгох, эдийн болон эдийн бус хохирлын үнэлгээг хуульд нийцүүлэн тогтоох аргачлалтай болж хэрэгт нотлох баримт болгох шаардлагатай байна. Ингэх нь гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг зөв, бодит тогтоох, нөхөн төлөх, төлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Т

⁵Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол. №15., 2009.5.22, УБ